



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/154

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 12 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд шаардагдах төсөв хөрөнгө дутагдалтай байгааг харгалзан Түнэл, Цагаан-Уул, Рашаант сумын Засаг даргын нөөцөд аймгийн Засаг даргын нөөцөөс хөрөнгө шилжүүлэх жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 12,416,200 (Арван хоёр сая дөрвөн зуун арван зургаан мянга хоёр зуун) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 05
дугаар сарын /0 –ны өдрийн
А/ 157 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦӨӨС ХӨРӨНГӨ
ШИЛЖҮҮЛЭХ СУМДЫН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Аймгийн Засаг даргын нөөцөөс шилжүүлэх хөрөнгийн хэмжээ
1	Түнэл	4916200
2	Цагаан-уул	5000000
3	Рашаант	2500000
	Бүгд	12,416,200

-----oOo-----